



## "УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар: 21/05

Улаанбаатар  
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  - 2.1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
  - 2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах.
  - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
  - 2.4. "Номин реалтор" ХХК-тай байгуулсан Барилгын ажлын захиалагчийн эрх, үүргийг шилжүүлэх гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй хэлцлийг танилцуулж батлуулах.
  - 2.5. Арилжааны банкнаас бага хүүтэй зээл авч, одоо байгаа зээлийг хаах, нэмэлт хөрөнгө оруулалтанд зарцуулах, Улсын их дэлгүүрийн барилгыг гуравдагч этгээдэд барьцаалуулах эрхийг "Номин холдинг" ХХК-д шилжүүлэх асуудлыг хэлэлцүүлж батлуулах.
3. Компани сүүлийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул 2020 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.
4. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр, 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрүүдэд "Өнөөдөр", "Үндэсний шуудан" гэсэн өдөр тутмын сонин болон TV9, UBS телевизүүдээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын материал, санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт болон бусад баримт бичиг, шийдвэрийн төсөлтэй хувьцаа эзэмшигчид Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр Даваагаас Баасан гарагуудад ажлын цагаар танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудаар дамжуулан тараахыг зөвшөөрсүгэй.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу “Номин юнайтед” цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Санжаагийн Сайнбатыг томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар тооцооны нягтлан бодогч Ж.Пүрэвжаргал, гишүүдээр өмгөөлөгч Б.Пүрэвдорж, Хүний нөөцийн мэргэжилтэн П.Хишигжаргал нарыг томилсугай.
14. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх И.Галбуян, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ө.ҮНЭНБҮРЭН